



САНГИЙН ЯАМНЫ ХУУЛЬ,  
ЭРХ ЗҮЙН ГАЗАРТ

**ДИСПЕТЧЕРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ**  
ТӨРИЙН ӨМЧИТ ХЯЗГААРЛАГДМАЛ  
ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ

17060 Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг,  
3-дугаар хороо, Засгийн газрын XIV байр  
Утас: 7004-1315, Факс: (976) 7004-3467  
E-mail: ndc@ndc.energy.mn

2023.03.29 № 01/422  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Тендер шалгаруулалтын хүчинтэй  
хугацаа сунгуулах тухай

Тус компани нь “Мэдээллийн технологийн системүүдийн нөөц сервер үүсгэх” ДҮТ/202301025 тоот тендер шалгаруулалтыг 2023 оны 03 дугаар сарын 02-ны өдөр зарлаж, 2023 оны 03 дугаар сарын 15-ны өдөр нээж, оролцогчоос ирүүлсэн материалыг үнэлж, байсан бөгөөд 03 дугаар сарын 16-ны өдрөөс “Худалдан авах ажиллагааны цахим систем” (www.tender.gov.mn)-д гэмтэл гарч оролцогчоос ирүүлсэн материал одоог хүртэл харах боломжгүй байна.

Одоогоор тус тендер нь цахим системд “Материал хүлээн авч байгаа төлөв”-тэй байх бөгөөд тендерийн үнэлгээ захиалагчаас үл хамаарах шалтгаанаар тодорхойгүй хугацаагаар сунгагдахаар байна.

Иймд “Мэдээллийн технологийн системүүдийн нөөц сервер үүсгэх” ДҮТ/202301025 шалгаруулалтын хүчинтэй хугацаа 2023 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр дуусах тул хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4 дэх заалтын дагуу тендер шалгаруулалтын хүчинтэй хугацааг 15 хоногоор сунгаж өгнө үү.

Хувийг: Төрийн худалдан авах ажиллагааны газарт

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



БАЛЖИННЯМ

0000007